




# ХҮН АМЫН САЛБАРЫН 2019 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



Хүн амын салбарын статистикийн танилцуулгатай холбоотой мэдээлэл  
ба санал хүсэлт байвал доорх хаяг болон вэб сайтад хандана уу.

---

**Хаяг:** АЗДТГазар Б байр,  
8-р баг, Мөрөн сум  
**Вэб сайт** <http://khuvsgul.nso.mn/>

#### **Холбогдох мэргэжилтэн**

**Утас:** 70383212 /С.Сармандах/  
**И-мэйл:** sarmandakh@nso.mn

**Танилцуулгыг боловсруулсан:** Хөвсгөл аймгийн Статистикийн хэлтсийн  
мэргэжилтэн С.Сармандах

# Агуулга

## ТҮҮХЭН ТОВЧОО

---


<b>БҮЛЭГ НЭГ: Хөвсгөл аймгийн хүн амын салбарын өнөөгийн байдал</b>	<b>5-15</b>
Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт	5-8
Хүн амын нас, хүйсийн бүтэц	9-11
Хүн амын суурьшил	12-12
Дундаж наслалт	12-13
Өрх	13-15
<hr/>	
<b>БҮЛЭГ ХОЁР: Хүн амын ердийн хөдөлгөөн</b>	<b>15-23</b>
Төрөлт	16-18
Нас баралт	18-19
Ердийн цэвэр өсөлт	19-20
Гэрлэлт	20-21
Цуцлалт	21-22
Үрчлэлт	23-23
<hr/>	
<b>БҮЛЭГ ГУРАВ: Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн</b>	<b>24-26</b>
Шилжин ирэлт	24-25
Шилжин явалт	25-26
<hr/>	
<b>БҮЛЭГ ДӨРӨВ: Дүгнэлт</b>	<b>27</b>

## Түүхэн товчоо

Хүн амын тооны өөрчлөлтийг төрөх, нас барах, шилжих хөдөлгөөнөөр тодорхойлдог. 2010-2020 оны хоорондох 10 жилийн хугацаанд хүн ам жилд дунджаар 1.7 хувиар, өмнөх тооллогоос жилийн дундаж өсөлт нь 1.3 пунктээр өссөн байна.

Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Хүн ам 1960-иад оны дунд үе хүртэл жилд дунджаар 0.3 хүртэл хувиар өсч байсан бол 1963-1969 онд 2.1 хувиар өссөн нь Хөвсгөл аймгийн түүхэн дэх хамгийн өндөр өсөлт юм. Хүн амын өсөлт 1979-1989 онд өмнөх үеэсээ 0.2 хувиар буурч байсан бол 1989-2000 онд жилд дундажаар 1.2 хувиар өсч байснаа 2010 онд 0.4 хувиар буурсан үзүүлэлт гарчээ (зураг 2.2). Хүн ам 1944-2000 оны хооронд жилд дунджаар 0.9-2.1 хувь тогтвортой өсч иржээ. Энэ нь ард түмний аж амьдрал үүний дотор, хүн амын эрүүл мэндийн түвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээгээр нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай холбоотой. Харин хүн амын тоо 2010-2020 оны тооллого хооронд дунджаар өсөлт төрөлт их байсан учир 1.7 хувь болж өссөн байна.

ЗУРАГ 1. Хөвсгөл аймгийн хүн амын тоо, тооллого явагдсан онуудаар




# БҮЛЭГ НЭГ. Хөвсгөл аймгийн хүн амын салбарын өнөөгийн байдал

## 1.1 Хүн амын тооны өсөлт, өөрчлөлт

Хөвсгөл аймгийн хүн амд: Хөвсгөл аймгийн нутаг дэсгэрт оршин суугаа хүн амыг хамруулна.

ЗУРАГ 1. Монгол улсын болон Хөвсгөл аймгийн хүн амын тоо, сонгосон онуудаар

**МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО,  
1918-2019, (МЯНГАН ХҮН)**



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮН АМЫН  
ТОО, 1956-2019, (МЯНГАН ХҮН)**



ЗУРАГ 3-д Монгол улсын хүн амын тоог саяар, Хөвсгөл аймгийн хүн амын тоог 30 мянгаар өөрчлөгдөх хугацааг авч үзлээ. Монгол улсын хүн амын тоог авч үзвэл 1 саяас 2 сая болж нэмэгдэхэд 26 жил байсан бол 2 саяас 3 сая болж нэмэгдэхэд мөн 26 жил болж 1 саяар нэмэгдэх хугацаа хэвийн байна. Харин Хөвсгөл аймгийн хүн амын хувьд 100 мянгаас 130 мянга болж нэмэгдэх хугацаа 30 жил байна.

## ЗУРАГ 2. Хөвсгөл аймгийн хүн амын тоо, 2019 он




Монгол Улсын нийт хүн ам 2019 онд 134 318 болж, өмнөх оныхоос 53 буюу 0.1 хувиар буурсан байна.

## ХҮСНЭГТ 1. Хөвсгөл аймгийн хүн амын тоо, сумаар


Сум, дүүрэг	Хүн ам 2017	Хүн ам 2018	Хүн ам 2019	2018/2017 (%)	2019/2018 (%)
Бүгд	132146	134371	134318	101.7	99.9
Алаг-Эрдэнэ	6526	6697	6743	102.6	100.7
Арбулаг	4000	4025	4032	100.6	100.2
Баянзүрх	4008	3984	3983	99.4	100.0
Бүрэнтогтох	4453	4423	4405	99.3	99.6
Галт	5494	5483	5430	99.8	99.0
Жаргалант	5319	5428	5548	102.0	102.2
Их-Уул	4129	4163	4110	100.8	98.7
Рашаант	3740	3828	3794	102.4	99.1
Ренчинлхүмбэ	4907	4904	4863	99.9	99.2
Тариалан	6096	6218	6209	102.0	99.9
Тосонцэнгэл	4344	4394	4451	101.2	101.3
Төмөрбулаг	4367	4373	4315	100.1	98.7
Түнэл	4214	4298	4323	102.0	100.6
Улаан-Уул	4259	4233	4242	99.4	100.2
Ханх	2783	2822	2818	101.4	99.9
Цагаан-Уул	5641	5728	5699	101.5	99.5
Цагаан-Үүр	2650	2684	2671	101.3	99.5
Цэцэрлэг	4538	4738	4658	104.4	98.3
Чандмань-Өндөр	3058	3126	3073	102.2	98.3
Шинэ-Идэр	3278	3278	3185	100.0	97.2
Мөрөн	39404	40510	40770	102.8	100.6
Эрдэнэбулган	2988	3056	3017	102.3	98.7
Цагааннуур	1950	1978	1979	101.4	100.1

ЗУРАГ 3. Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь



Хөвсгөл аймгийн суурин хүн ам 2019 онд 134 318 болж, өмнөх оныхоос 53 буюу 0.1 хувиар буурсан байна (ЗУРАГ 3). Хүн амын тоо ерөнхийдөө өсч байгаа боловч өсөлтийн хурд тогтвортой байсангүй. Тухайлбал, хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 2014 оноос хойш тогтвортой өссөөр, 2016, 2019 онуудад буурсан байна.

ЗУРАГ 4. Монгол Улсын хүн амын ердийн хөдөлгөөний үзүүлэлтүүд, 2019 он



Хөвсгөл аймагт оршин суугаа хүн ам 2019 онд 134318 болж, өмнөх оноос 0.1 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд 2019 онд 3210 эх амаржиж 3244 хүүхэд төрсөн байна. Харин нас баралт 847 болсон нь өмнөх оноос 4.7 хувиар өссөн байна. Нийт 710 хос 2019 онд гэрлэлтээ бүртгүүлж, 113 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 72 хүүхэд үрчлүүлсэн байна. Хөвсгөл аймагт шинэ төрсөн эрэгтэй хүүхэд цаашид 63.94 жил, эмэгтэй хүүхэд 71.99 жил амьдарна гэсэн тооцоо гарсан нь улсын дундажаас эрэгтэй 2.44, эмэгтэй 3.97 жилээр бага байна.

Өрхийн тоо 2019 оны эцэст 37 914 болсны 33.7 хувь нь хотод, 66.3 хувь нь хөдөө байгаа бөгөөд аймгийн дунджаар нэг өрхөд 3.5 хүн ногдож байна.




## 1.2 Хүн амын нас, хүйсийн бүтэц

Нас, хүйсийн бүтэц нь хүн ам зүйн хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Улс орнуудын хүн амын нас, хүйсийн бүтэц өөр хоорондоо харилцан адилгүй байдаг ба нийгэм, эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн асуудалд ихээхэн хэмжээний нөлөө үзүүлдэг.

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Ингэснээрээ хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог. Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан, эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран үе үеийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг.

ЗУРАГ 5. Хүн амын нас, хүйсийн суварга, 2018, 2019 он




Хүн амын нас, хүйсийн суваргаас харахад, дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн амын насны бүтэц идэрших хандлагатай байгааг харуулж байна. Харин 10-19 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин эрс буурч байсныг харуулж байна. Нийт хүн амын 63.3 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Дээрх суваргад хөдөлмөрийн насны хүн ам буюу 25-34 насны бүлгийн хүн ам харьцангуй их харагдаж байна.

Хүн амын дунд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж байгааг (ЗУРАГ 6) харж болно. Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг “Хүн ам зүйн цонх” гэдэг. Энэ үед улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эерэгээр нөлөөлдөг.


Хүн ам зүйн цонх нээгдсэн үед хүүхэд, залуучуудын боловсролын түвшинг дээшлүүлэх, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд ажиллах хүчний нөөц хүрэлцэхүйц байх нөхцөл бүрэлдсэн гэж ойлгож болох юм.

ЗУРАГ 6. Хүн амын насны бүтэц, сонгосон онуудаар



2019 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл нийт хүн амын 31.6 хувь нь **15 хүртэлх насны хүүхэд**, 64.3 хувь нь **15-64 насны хүмүүс**, 4.1 хувь нь **65 ба түүнээс дээш** насны өндөр настан байна. Нийт 0-14 насныхны эзлэх хувь 2019 онд 1979 оноос 14.6 пункт, 60 ба түүнээс дээш насныхны хувийн жин 4.2 пунктаар тус тус буурч харин 15-59 насныхны хувийн жин 18.9 пунктаар өссөн байна. Төрөлт сүүлчийн 20-иод жилийнх шиг тасралтгүй буурвал хүн амын насны бүтэц удахгүй өөрчлөгдөх хандлагатай байна.

ЗУРАГ 7. Хүн амын хүйсийн харьцаа, 2019 он



Хүн амын хүйсийн харьцааг насны бүлгээр авч үзвэл 2019 онд 0-34 насны бүлэгт 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү, 30 ба түүнээс дээш насны бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Хүн ам зүйн цонх үеийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг нь хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн тоо гэсэн үзүүлэлт юм. Хүн ам зүйн ачаалал 2019 онд 55.5 байгаа нь хөдөлмөрийн насны 2 хүнд хөдөлмөрийн бус насны 1 хүн ногдож байгааг харуулж байна. Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн насны нэг хүн хичнээн хүнийг тэжээн тэтгэж болохыг илэрхийлж байгаа болохоор урт хугацааны бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарснаар улс орны нийгэм, эдийн хөгжилд хүн ам зүйн хүчин зүйл эергээр нөлөөлөх юм.

#### ХҮСНЭГТ 2. Хүн ам зүйн ачаалал, сонгосон онуудаар

Үзүүлэлтүүд	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Голч нас /жилээр/	26.3	26.7	26.4	26.5	26.4	26.8
Хүн ам зүйн ачаалал /хувиар/	48.7	51.4	51.1	52.0	53.7	55.5
Хөгшрөлтийн индекс	13.9	13.8	12.2	12.3	11.9	12.3


Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа голч нас 26.8 болсон нь хүн амын тэн хагас нь 26.8-оос доош, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байна.

Хөгшрөлтийн индекс буюу 0-15 насны 100 хүүхдэд ногдох 65, түүнээс дээш настай хүний тоо 12.3 байна.

### 1.3 Хүн амын суурьшил

Хөвсгөл аймгийн хүн амыг суурьшлаар нь харвал хотод 32.9 хувь, хөдөөд 67.1 хувь нь суурьшиж байна. Үүнээс 30.3 хувь нь Мөрөн суманд оршин сууж байна. Төв суурин газар уруу 1990-ээд оны эхэн үеэс эхэлсэн шилжилт сүүлийн 20 гаруй жилд үргэлжилсэн хэвээр байна. Ерөнхийдөө хүн амын шилжилт хөдөлгөөн Мөрөн сумруу чиглэж байгаа нь олон баримтаас харагддаг.

ЗУРАГ 8. Хүн амын нягтрал, сумаар, 2019 он




Хөвсгөл аймгийн хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.5 хүн ногдож байсан бол 2010 онд 1.7 хүн, 2019 онд 1.3 болж буурсан байна.

### 1.4 Дундаж наслалт

Хүний амьдрах хугацааг тодорхойлох гол хэмжүүр нь “ДУНДАЖ НАСЛАЛТ” юм. Төрөлтөөс тооцсон дундаж наслалт<sup>2</sup> 2019 онд аймгийн хэмжээнд 67.09 болж өмнөх оноос 0.38 пунктээр буурсан бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 63.94, эрэгтэйчүүдийнх 71.99 жил болсон нь улсын дундажаас эрэгтэй 2.44, эмэгтэй 3.97 жилээр бага байна.

ЗУРАГ 9. Хүн амын дундаж наслалт, хүйсээр, 2019 он



Дундаж наслалт нь таамаглах хэмжигдэхүүн бөгөөд насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог. Тухайн улсын хүн амын дундаж наслалтыг төрөлтөөс тооцсон дундаж наслалтаар тодорхойлдог. Дундаж наслалт нь хүйс, одоогийн нас, амьдралын хэв маяг зэргээс шалтгаалан ялгаатай байдаг. Тухайлбал, 60 настай эрэгтэй цаашид 12 жил, 55 настай эмэгтэй цаашид 9 жил наслах тооцоо гарсан байна.

### 1.5 Өрх

Өрхийг “Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо садан төрлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно. Өрх гэдэг ойлголт нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно” гэж тодорхойлдог. 2019 онд нийт өрхийн тоо 37914 болж өмнөх оноос 3.9 хувиар буурч харин 2010 оноос 8 хувиар өссөн байна. Нийт өрхийн 33.7 хувь нь хотын өрх, үлдсэн хувь нь хөдөөгийн өрх байна. Аймгийн дунджаар нэг өрхөд 3.5 хүн ногдож байна.

ЗУРАГ 10. Өрхийн зарим үзүүлэлт, 2019 он



Өрхийн ам бүлийн дундаж тоо Тосонцэнгэл, Улаан-Уул, Цагааннуур сумдад хамгийн өндөр буюу аймгийн дундажаас 0.3 пунктээр их байна.

Арбулаг, Галт, Жаргалант, Рашаант, Ренчинлхүмбэ, Тариалан, Төмөрбулаг, Цагаан-Уул, Цэцэрлэг, сумдын өрхийн ам бүлийн дундаж тоо аймгийн дундажаас 0.1-0.2-оор илүү байгаа нь харагдаж байна.

Долоо, түүнээс дээш ам бүлтэй өрхийн нийт өрхөд эзлэх хувь Улаан-Уул суманд аймгийн дундажаас 1.2 пунктээр илүү байна. Харин Мөрөн сум буюу төв суурин газар энэ үзүүлэлт аймгийн дундажтай ижил байна.

### ХҮСНЭГТ 3. Өрхийн тоо, ам бүлийн тоо, сумаар, 2019 он

Аймаг, нийслэл	Ам бүлийн тоогоор					Өрхийн ам бүлийн дундаж тоо
	Бүгд	1-2	2-3	4-5	7+	
<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>31.5</b>	<b>40.3</b>	<b>24.1</b>	<b>4.1</b>	<b>3.5</b>
Алаг-Эрдэнэ	100	35.9	39.6	20.9	3.6	3.3
Арбулаг	100	33.0	38.7	23.3	5.0	3.7
Баянзүрх	100	29.5	39.1	26.5	4.9	3.7
Бүрэнтогтох	100	32.8	37.0	26.5	3.8	3.5
Галт	100	26.9	42.4	28.1	2.6	3.6
Жаргалант	100	30.3	41.2	25.1	3.4	3.6
Их-Уул	100	33.4	37.5	26.3	2.8	3.5
Рашаант	100	31.4	37.8	26.4	4.3	3.6
Ренчинлхүмбэ	100	27.8	44.2	24.1	3.9	3.6
Тариалан	100	30.7	39.1	25.9	4.3	3.6
Тосонцэнгэл	100	28.2	36.8	30.6	4.4	3.8
Төмөрбулаг	100	28.4	42.4	24.9	4.3	3.7
Түнэл	100	37.3	33.6	24.5	4.6	3.4
Улаан-Уул	100	24.9	42.3	27.5	5.3	3.8
Ханх	100	30.9	39.9	25.5	3.7	3.5
Цагаан-Уул	100	27.0	40.7	28.3	4.0	3.7
Цагаан-Үүр	100	31.9	42.2	23.1	2.8	3.4
Цэцэрлэг	100	28.8	43.4	24.5	3.3	3.6
Чандмань-Өндөр	100	34.2	39.1	23.1	3.6	3.4
Шинэ-Идэр	100	32.2	45.0	21.1	1.7	3.4
Мөрөн	100	33.5	40.6	21.3	4.6	3.5
Эрдэнэбулган	100	30.2	41.5	24.2	4.1	3.5
Цагааннуур	100	25.8	40.3	28.9	5.0	3.8

## БҮЛЭГ ХОЁР. Хүн амын ердийн хөдөлгөөн


Ердийн хөдөлгөөнд төрөлт, нас баралт, гэрлэлт, гэр бүл дуусгавар болголт, үрчлэлт багтана.

### 2.1 Төрөлт

Төрөлт нь хувь хүн, хосууд, хүн төрөлхтөний дунд явагдаж буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.


Аймгийн хэмжээнд 2019 онд 3244 хүүхэд төрснөөс 51.2 эрэгтэй, 48.8 хувь нь эмэгтэй хүүхэд байна. 2019 оны төрөлт 2018 оноос 2.2 хувиар өссөн.

ЗУРАГ 11. Хөвсгөл аймгийн төрөлтийн тоо, 2010 он, 2019 он



Хөвсгөл аймгийн төрөлтийн тоог сүүлийн 10 жилээр харвал 2014 онд хамгийн өндөр, 2010 онд хамгийн бага төрөлттэй байна.


ЗУРАГ 12. Сүүлийн 10 жилд хамгийн өндөр болон бага төрөлттэй жил






2019 байдлаар төрөлтийн тоог эхийн насны бүлгээр авч үзвэл нийт төрөлтийн 29.0 хувь нь 20-24 насандаа, 27.1 хувь нь 25-29 насандаа, 20.8 хувь нь 30-34 насандаа төрсөн байна.

ЗУРАГ 13. Төрөлтийн тоо, эхийн насны бүлгээр, 2019 он



Төрсөн хүүхдийг эцгийн насны бүлгээр авч үзвэл эцгийн 24.6 хувь нь 25-29 насандаа, 20.5 хувь нь 30-34 насандаа, 15.9 хувь нь 20-24 насандаа, 10.5 хувь нь 35-39 насандаа эцэг болсон байна.

ЗУРАГ 14. Төрөлтийн тоо, эцгийн насны бүлгээр, 2019 он




Манай аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 105 хөвгүүн ногдож байна. Мөрөн сумын төрөлтийн тоо Хөвсгөл аймгийн нийт төрөлтийн түвшний 29.3 хувийг эзэлж байна.

## 2.2 Нас баралт

Нас баралтын түвшин нь тухайн хүн амын нас, хүйсийн бүтэц, арьс өнгө, ажил эрхлэлтийн байдал болон нийгмийн тодорхой анги бүлэг гэх мэт олон төрлийн хүчин зүйлээс шалтгаалдаг. Хүн амын нас баралт 2019 онд 847 болж өмнөх оноос 4.5 хувиар өссөн байна. Сүүлийн 10 жилд нас баралт 2011 онд хамгийн их буюу 956, 2012 онд хамгийн бага буюу 635 байжээ.

ЗУРАГ 15. Нас баралтын тоо, сүүлийн 10 жилд хамгийн их, бага оноор



2019 оны байдлаар нас барсан 847 хүнээс дээд боловсролтой 4 хувь, бүрэн дунд болон тусгай дунд 38 хувь, бага болон суурь боловсролтой 43 хувь, боловсролгүй 15 хувь нь байна. Нас баралтыг гэрлэлтийн байдлаар авч үзвэл, 41.2 хувь нь огт гэрлээгүй болон бэлэвсэн, 56.3 хувь нь гэрлэсэн батлуулсан, 2.5 хувь нь тусгаарласан болон цуцалсан хүмүүс байна.

Нас баралтыг нас барсан газраар авч үзэхэд 66.4 хувь нь гэртээ, 21.9 хувь нь эмнэлэгт, 11.7 хувь нь ажил дээрээ, тээврийн хэрэгсэл, хээр, гадаа болон бусад газар нас барсан байна.

ЗУРАГ 16. Нас баралт, нас барсан газар, 2019 он



Монгол Улсын 1000 хүнд ногдох нас баралт 5.8 байгаа нь улсын дундажаас 0.6 пунктээр их байна.

### 2.3 Ердийн цэвэр өсөлт

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойших сумдын хүн амын өсөлт эрс тэс ялгаатай болсон нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Энэ нь гагцхүү шилжих хөдөлгөөнтэй холбоотой гэж үзэж болно. Учир нь хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент бүх суманд сүүлчийн 5 жилд дунджаар 13-24 промилл байсан. 2018-2019 онд хүн ам буурсан сумдад хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент сүүлчийн 5 жилд 9-21 промиллын хооронд хэлбэлзэж байна. Үүнийг суурин хүн амд эзлэх хувиар харвал хүн амын тоо төрөлтөөс шалтгаалан 1000 хүн тутамд ойролцоогоор 9-21 нэмэгдсэн байна гэсэн үг юм.


ХҮСНЭГТ 4. Сумын хүн амын ердийн цэвэр өсөлтийн коэффициент, 2015-2019 он

	2015	2016	2017	2018	2019
Алаг-Эрдэнэ	11	21	17	17	18
Арбулаг	21	26	19	19	24
Баянзүрх	19	21	10	19	21
Бүрэнтогтох	20	21	18	15	16
Галт	18	17	15	14	17
Жаргалант	21	17	15	20	20
Их-Уул	10	15	18	13	14
Рашаант	15	16	13	22	15
Ренчинлхүмбэ	16	17	12	14	17
Тариалан	16	12	15	18	15
Тосонцэнгэл	20	16	20	19	18
Төмөрбулаг	15	16	16	21	22
Түнэл	17	23	16	22	19
Улаан-Уул	18	18	11	20	24
Ханх	17	20	16	17	16
Цагаан-Уул	23	15	18	18	22
Цагаан-Үүр	21	17	9	16	13
Цэцэрлэг	18	18	15	22	18
Чандмань-Өндөр	11	15	10	19	11
Шинэ-Идэр	13	12	10	13	16
Мөрөн	21	18	18	21	18
Эрдэнэбулган	22	19	15	17	16
Цагааннуур	20	24	19	19	21

#### 2.4. Гэрлэлт

Нийт 707 хос 2019 онд гэрлэлтээ бүртгүүлсэн ба өмнөх оноос 10.4 хувиар буурсан байна. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоог насны бүлэг болон хүйсээр авч үзвэл 20-34 насны хувьд нийт гэрлэлтээ бүртгүүлсэн эрэгтэйчүүдийн 89.3 хувь, эмэгтэйчүүдийн 85.1 хувь нь байна.

ЗУРАГ 17. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо, хүйсээр, 2019 он



Гэрлэлтээ бүртгүүлсэн нийт эрэгтэй хүний 94.3 хувь, эмэгтэйчүүдийн 91.0 хувь нь анхны гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Мөн гэрлэлтээ бүртгүүлсэн нийт эрэгтэйчүүдийн 1.0 хувь, эмэгтэйчүүдийн 1.8 хувь нь гэрлэлтийн өмнөх статус нь бэлэвсэн байсан байна.


ЗУРАГ 18. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо, хэд дэх гэрлэлт, хүйсээр, 2019 он



## 2.5 Цуцлалт


Нийт 2019 онд 113 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, өмнөх оноос 21.0 хувиар буурсан байна. Нийт гэрлэлтээ дуусгавар болгосон эрэгтэйчүүдийн дийлэнх буюу 61.0 хувь, эмэгтэйчүүдийн 69.0 хувь нь 25-39 насандаа гэр бүлээ цуцлуулж байна.

ЗУРАГ 19. Гэрлэлтээ дуусгавар болгосон хүний тоо, хүйсээр, 2019 он



Харин 18, түүнээс дээш насны 1000 хүнд ногдох гэрлэлт 2010 онд 5.6 байсан бол 2018 онд 9.2 харин 2019 онд 8.2 болж өмнөх оноос 1 пунктээр буурсан байна. Гэр бүл цуцлалт 2010 оноос хойш аажмаар буурсаар 2019 онд 1.3 болж өмнөх оноос 0.4 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 20. 1000 хүнд ногдох гэрлэлт, цуцлалт, 2010-2019 он




## 2.6 Үрчлэлт

Нийт 72 хүүхэд үрчлэгдэж, өмнөх оноос 30.8 хувиар буурсан байна. 2019 онд 72 хүүхэд үрчлэгдсэний 72 хувь нь 3 хүртэлх насны, 18.1 хувь нь 3-6 насны, 5.5 хувь нь 7-9 насны, үлдсэн 4.4 хувь нь 10 ба түүнээс дээш насны хүүхдүүд байна. Хүйсээр авч үзвэл 33 эрэгтэй, 39 эмэгтэй хүүхэд үрчлэгдсэн байна.

Үрчлэгдсэн хүүхдийг эцгийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч 51.4 хувь нь цалин хөлстэй ажиллагч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2.8 хувь нь ажилгүй байна. Харин эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар авч үзвэл 51.4 хувь нь цалин хөлстэй ажиллагч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, 9.7 хувь нь ажилгүй байна

ЗУРАГ 21. Үрчлэгдсэн хүүхдийн тоо, эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлтийн байдлаар, 2019 он



## БҮЛЭГ ГУРАВ. Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн

Монгол Улсын “Иргэний улсын бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 1-д “Иргэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг байнга, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг түр оршин суух гэнэ” гэж тодорхойлсон байдаг. Олон улсын аргачлалаар, шилжигч гэдгийг тодорхойлохдоо 1 сар, 1 жил, 5 жил гэх мэт хугацааг шалгуур болгохыг зөвлөсөн байдаг бол Монгол Улсын хувьд тухайн орон нутагт 6 сар, түүнээс дээш хугацаагаар оршин суухаар ирж буй хүмүүс шилжин ирэгч гэсэн ойлголтод хамаарах ба дээрх хугацаагаар уугуул орон нутгаасаа явж буй хүмүүс шилжин явагч гэсэн тодорхойлолтод багтана.

2019 оны жилийн эцэст 714 хүн шилжин ирж, 1284 хүн шилжин явсан байна. Өмнөх онтой харьцуулбал шилжин ирэлт 35 хувиар буурч харин шилжин явалт 31 хувиар өссөн байна.

ЗУРАГ 22. Хүн амын шилжилт хөдөлгөөн, 2011-2019 он



### 3.1 Шилжин ирэлт

2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 714 хүн шилжин ирсэн байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин ирэлтийн коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо бөгөөд 2011 онд 6.3, 2017 онд 9.2 болж өсөж, 2019 онд 5.3 болж буурсан байна.



ЗУРАГ 23. Шилжин ирсэн хүний тоо, шилжин ирэлтийн коэффициент, 2011-2019 он



2019 оны жилийн эцсийн байдлаар шилжих хөдөлгөөнд оролцогчдын дотор идэвхтэй нас буюу 0-4 болон 20-34 насны хүн ам шилжин ирэгчдийн 57.0 хувийг эзэлж байна. Нийт шилжин ирэгчдийг хүйсээр авч үзвэл 53.1 хувийг эрэгтэйчүүд, 46.9 хувийг эмэгтэйчүүд байна. Шилжин ирэгчдийг сумдаар авч үзвэл Мөрөн суманд шилжин ирэгчдийн тоо бусад сумуудтай харьцуулахад хамгийн өндөр байна. Нийт шилжин ирсэн хүн амын 43.4 хувь нь Мөрөн суманд шилжиж ирсэн байна.

### 3.2 Шилжин явалт

2019 оны байдлаар 980 хүн байнга оршин суудаг засаг захиргааныхаа нэгжээс шилжин явсан байна. Хүн ам зүйн судалгааны шилжих хөдөлгөөнтэй холбоотой чухал үзүүлэлтүүдийн нэг нь шилжин явалтын коэффициент юм. Энэ үзүүлэлт нь 1000 хүнд ногдох шилжин явагчдын тоо бөгөөд 2019 онд 1000 хүн тутмын 10 нь байнга оршин сууж байсан засаг захиргааны нэгжээсээ шилжин явсан нь 2011 оныхоос 7 пунктээр буурч, 2018 оноос 3 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 24. Шилжин явсан хүний тоо, шилжин явалтын коэффициент, 2011-2019 он



Шилжин явагчдыг насны бүлгээр авч үзвэл, 2019 оны байдлаар 0-4 болон 20-34 насныхан нийт шилжин явагчдын 61.9 хувийг эзэлж байна. Шилжин явагчдыг хүйсээр авч үзвэл 46.3 хувь нь эрэгтэйчүүд, 53.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Шилжин явагчдын сумдаар нь авч үзвэл Мөрөн, Жаргалант, Тариалан, Цэцэрлэг сумдад шилжин явагчдийн тоо бусад сумтай харьцуулахад хамгийн өндөр байна. 2019 онд нийт шилжин явсан хүн амын 42.5 хувь нь Мөрөн сумаас, 5.1 хувь нь Тариалан, 4.5 хувь нь Жаргалант, 4.3 хувь нь Цэцэрлэг сумдаас шилжиж явсан байна.

## БҮЛЭГ 4. Дүгнэлт

Хөвсгөл аймгийн суурин хүн ам 2019 онд 134 318 болж, өмнөх оныхоос 53 буюу 0.1 хувиар буурсан байна. Хүн амын тоо ерөнхийдөө өсч байгаа боловч өсөлтийн хурд тогтвортой байсангүй. Тухайлбал, хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 2014 оноос хойш тогтвортой өссөөр, 2016, 2019 онуудад буурсан байна..

Өрхийн тоо 2019 оны эцэст 37 914 болсны 33.7 хувь нь хотод, 66.3 хувь нь хөдөө байгаа бөгөөд аймгийн дунджаар нэг өрхөд 3.5 хүн ногдож байна.

Хөвсгөл аймгийн хүн амын нягтрал 2000 онд нэг квадрат километр нутаг дэвсгэрт 1.5 хүн ногдож байсан бол 2010 онд 1.7 хүн, 2019 онд 1.3 болж буурсан байна.

2019 оны нийт хүн амыг насны бүлгээр авч үзвэл нийт хүн амын 31.6 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 64.3 хувь нь 15-64 насны хүмүүс, 4.1 хувь нь 65 ба түүнээс дээш насны өндөр настан байна. Хүн ам зүйн ачаалал 2019 онд 55.5 байгаа нь хөдөлмөрийн насны 2 хүнд хөдөлмөрийн бус насны 1 хүн ногдож ногдож байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд 3244 хүүхэд төрснөөс 51.2 эрэгтэй, 48.8 хувь нь эмэгтэй хүүхэд байна. 2019 оны төрөлт 2018 оноос 2.2 хувиар өссөн байна. Манай аймгийн хүн амын төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охинд ойролцоогоор 105 хөвгүүн ногдож байна. Мөрөн сумын төрөлтийн тоо Хөвсгөл аймгийн нийт төрөлтийн түвшний 29.3 хувийг эзэлж байна.

Хүн амын нас баралт 2019 онд 847 болж өмнөх оноос 4.5 хувиар өссөн байна. Сүүлийн 10 жилд нас баралт 2011 онд хамгийн их буюу 956, 2012 онд хамгийн бага буюу 635 байжээ.

Нийт 710 хос 2019 онд гэрлэлтээ бүртгүүлж, 113 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 72 хүүхэд үрчлүүлсэн байна. Хөвсгөл аймагт шинэ төрсөн эрэгтэй хүүхэд цаашид 63.94 жил, эмэгтэй хүүхэд 71.99 жил амьдарна гэсэн тооцоо гарсан нь улсын дундажаас эрэгтэй 2.44, эмэгтэй 3.97 жилээр бага байна.

2019 оны жилийн эцэст 714 хүн шилжин ирж, 1284 хүн шилжин явсан байна. Өмнөх онтой харьцуулбал шилжин ирэлт 35 хувиар буурч харин шилжин явалт 31 хувиар өссөн байна.